



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Чойбалсан хот

2018 он

АГУУЛГА

Аймгийн товч танилцуулга.....	3
Орон сууцны нөхцөл.....	8
Ахуйн нөхцөл.....	9
Нийгмийн зарим үзүүлэлт.....	13
Эрүүл мэндийн салбарын үзүүлэлт.....	14
Сурч, боловсрох нөхцөл.....	15
Гэмт хэргийн үзүүлэлт.....	16



## ДОРНОД АЙМАГ

Монгол Улс Ази тивийн төвд, хойт өргөргийн 410 35" – 520 06", зүүн уртрагийн 870 47" – 1190 57"-ийн хооронд байрлаж, хойт талаараа Оросын Холбооны Улстай 3543 км, өмнө талаараа Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 4709.6 км хиллэдэг бол Дорнод аймаг нь Монгол Улсын зүүн хязгаарт байрлалтай.

Дорнод аймгийн газар нутаг нь Монгол улсын анхны гурван аймгийн нэг болсон Сэцэн хан аймагт 1627 оноос, Хэрлэн барсын чуулганд 1728 оноос, Хан хэнтий уулын чуулганд 1911 оноос харьяалагдаж байжээ.

Богд хаант засгийг 1924 онд халж, ардын захиргааг шинээр байгуулахад Хан Хэнтий уулын аймагт 24 сумтайгаар харьяалагдах болсон байна.

Ардын Засгийн газрын 1931 оны 2 сарын тогтоолоор Хан Хэнтий уулын аймгаас 10 хошууг шилжүүлэн Дорнод аймгийг байгуулсан түүхтэй.

1945 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн тогтоолоор Чойбалсан аймаг гэж нэрлэх болж, аймгийн төвийг Баянтүмэн хот гэж нэрлэж байсан.

БНМАУ-ын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 3 дугаар сарын 21-ний 68 дугаар зарлигаар Чойбалсан аймгийг Дорнод аймаг гэж нэрлэсэн.

Тус аймаг нь Засаг захиргааны 14 сум, 66 багтай, зүүн бүсийн тулгуур төв юм.

Аймгийн хэмжээнд 23.3 мянган өрхөд 77.7 мянган хүн амьдарч байгаагийн 12925 өрх буюу 55.4 хувь нь аймгийн төвд, 4701 өрх буюу 20.1 хувь нь сумын төвд, 5698 өрх буюу 24.4 хувь нь хөдөө амьдарч байна.

Халх, буриад, барга, үзэмчин зэрэг үндэстэн зонхилон амьдардаг.

Газар зүй: Чойбалсан хот нийслэл Улаанбаатар хотоос 656 км зайд Монгол улсын зүүн хилд оршдог бөгөөд 123.5 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, нутгийн хойд талаараа Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн хязгаарын Кыра, Акша, Онон, Борзь районтай, зүүн хойт, зүүн, зүүн урд талаараа 1155 км-ээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөлөнбуйр, Хянган, Шилийн гол зэрэг үзэмчин аймагтай, урд, баруун урд талаараа 452 км-ээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Түмэнцогт сумтай, баруун, баруун хойд талаараа 216 км-ээр Хэнтий аймгийн Баян-Овоо, Дадал, Норовлин сумтай тус тус хиллэдэг.

Монгол Улсад байдаг усан хилийн нэг хэсэг нь манай аймгийн нутагт байдаг. Буйр нуурын усаар БНХАУ-тай 30.7 км-ээр хиллэдэг. Буйр нуур ДТД 581 метрт өргөгдсөн бөгөөд 615 хавтгай дөрвөлжин км талбайтай, хамгийн гүндээ 50 м, цэнгэг устай, 20 гаруй төрлийн агнуурын загастай.

Хэнтий нуруунаас эх авсан Хэрлэн (1090км), Онон(292 км), Улз (428 км), Хянганы нуруунаас эх авсан Халх, Нөмрөг голуудаас гадна олон гол горхи, цөөрөмтэй. Хээрийн болон усны төрөл бүрийн шувуудтай.

Тус аймгийн нутгийн өмнө хэсэгт Мэнэн, Тамсагбулаг, Бадам-Ишийн өргөн уудам тал нутаг бараг 300 орчим км үргэлжилдэг.

Нутаг дэвсгэрийн ихэнх нь хүрэн хөрстэй, Онон, Улз, Халхголын дагуу хар шороон хөрстэй, Халхголын орчимд тариаланд нэн тохиромжтой 273,3 мянган га талбай байдаг ба улсын хэмжээний хадлангийн талбайн 54 хувь, газар тариаланд тохиромжтой талбайн 22 хувь, малын бэлчээрийн 10 хувийг эзэлдэг, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Халхгол сумдуудад бага зэргийн нарс, шилмүүст, хусан ой мод байдаг.

Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1503 м өндөр Соёлз уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 552 м Хөх нуурын хонхор бөгөөд энэ нь Монгол улсын нутгийн хамгийн нам цэг юм.

Соёлз уул далайн түвшнээс дээш 1503 м, Эрээн 1376 м, Баян-Уул 1298 м, Лүн 1218 м зэрэг уулстай.

Цагаан зээр, бор гөрөөс, чоно илбэнх, шилүүс, нохой зээх, заарт харх, үнэг, хярс, тарвага зэрэг олон төрлийн ан амьтантай ба нутгийн зүүн өмнөд хэсэгт орших Халхгол сумын нутагт их Хянганы нурууны үргэлжлэл оршдог ба түүнд буга, хандгай, баавгай, гахай, халиу зэрэг ан гөрөөс, ой мод, гол устай байгалийн үзэсгэлэнт газар нутаг БНХАУ-лстай хил залгаа оршдог

Манай аймаг Монгол Улсад ганцхан хялганат хээр тал, зах хязгааргүй үргэлжлэх уудам талаараа алдартай, цөөнгүй газар нутаг, Дархан цаазтай бөгөөд тусгай хамгаалалтын болон байгалийн нөөц ангиллаар төрийн тусгай хамгаалалтад байдаг. Монгол дагуурын дархан цаазтай газар, Дорнод Монголын тал, Нөмрөг гэсэн гурван дархан цаазтай бүс байхаас гадна, Цагаан-Овоо сумын нутагт байх Тосон хулстай 4800 ам километр газрыг 1988 оноос, Баяндун сумаас зүүн тийш 30 гаруй км зайд орших ДТД 1025 м өндөрт Угтам уулын 462 км талбайг хамруулан 1993 онд, Сэргэлэн сумын нутагт орших Яхь нуурын 2514 ам км талбайг газар нутгийг 1998 онд байгалийн нөөцийн газарт бүртгэж, тусгай хамгаалалтад авсан.

Тус аймгийн жилийн 251-260 өдөр нь нартай цэлмэг, жилд дунджаар 160-300 мм тундас унаж, цаг агаарын дундаж -26 хэмээс +27 хэм байдаг ба жилд дунджаар 57 удаа бороо орж, 25 удаа цас ордог бөгөөд Эх газрын эрс тэс уур амьсгалтай, салхины ноёлох чиглэл баруун хойноосоо байдаг. 1 дүгээр сарын дундаж температур -200-210 С, 7 дугаар сарын дундаж температур +180+200 С байдаг. Хаврын цагт салхины эрч

хүч ихэсч чиглэл нь тогтворгүй бөгөөд энэ нь улиралын 60 орчим хоногт тогтмол хүчтэй салжилж, цасан болон шороон шуурга үргэлжилдэг.

Дорнод аймаг түүхэн дурсгалт газрууд олонтой. Хүннү гүрнээс эхлээд хожмын Кидан гүрэн, Их монгол улсын түүхэнд холбогдох чухал дурсгалт газрууд олонтойгоос гадна хамгийн ойрын жишээг хэлэхэд Халхын голын дайн болж өнгөрсөн байдаг.

Дорнод нутгаас салбар бүрт олон алдартнууд төрөн гарсан байдаг. Ганцхан хүнийг дурдахад БНМАУ-ын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн, Төрийн шагналт зураач, Дорнод аймгийн Баяндун сумын харьяат Додийн Чойдог агсан 1945 онд Монгол Улсын Төрийн далбааг зурж, Сайд нарын зөвлөлөөс баталснаар өнөөг хүртэл дээдлэн хэрэглэж байна.

Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэгч аймгийн Засаг дарга бөгөөд 7 хэлтэс, 2 албатай Засаг даргын Тамгын газар, Төрийн Аудитын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Гаалийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Ус, цаг, орчны шинжилгээний газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Статистикийн хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Биеийн тамир, спортын газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Шүүхийн шинжилгээний алба зэрэг агентлагуудаар дамжуулан төрийн үйл ажиллагааг явуулж байна.

Дорнод аймагт нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлдэг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 35 төлөөлөгчтэй үйл ажиллагаа явуулдаг.

Тус аймгийн нутаг дэвсгэрт Зэвсэгт хүчний 085, 327, 329 дүгээр анги, салбар, Хилийн 0132, 0198, 0275, 0306 дугаар анги, 30 гаруй хилийн суман байрладаг.

Аж үйлдвэрлэл: Дорнод аймаг үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр бүтээн байгуулалт сайтай.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Адуунчулуун” ХК, “МАК”ХК, “ДорнодНАА” ОНӨААТҮГ, “Дорнод худалдаа” ХК, “Хэрлэн Номин бизнес” худалдааны төв зэрэг томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд байдаг.

2017 оны жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 57.6 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.7 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан бол оны үнээр 56.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 0.9 тэрбум төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

Энэ онд гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс 526.4 мянган тонн нүүрс олборлож, 252212.7 мянган.квт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 269557 г.кал дулаан нийлүүлж, 3183.8 тн гурил, 1708.4 тн хивэг, 666.7 тн талх, нарийн боов, 5.1 мян.л дарс, 145.2 мян.ширхэг зайрмаг, 8.8 тн хиам, банш бууз тус тус үйлдвэрлэсэн байна.

Авто зам, Нийтийн тээвэр: Дорнод аймаг нь Чойбалсан-Өндөрхаан, Чойбалсан-Баруун-Урт, Чойбалсан-Ульхан, Чойбалсан- Сүмбэр, /Халхгол сум/ Чойбалсан-Эрээнцав, Чойбалсан-Хавирга хилийн боомт зэрэг улсын чанартай автозамуудтай. Улсын чанартай авто замын засвар, арчлалтыг "Дорнод авто зам" ХК, Орон нутгийн чанартай авто замын арчлалыг "Авто агро" ХХК хариуцан ажиллаж байна.

Хот хоорондын нийтийн тээврийн үйл ажиллагааг "Айсвн" ХХК- 9, "Аж мянган" ХХК- 20 том оврын тээврийн хэрэгслээр, аймаг, сум хоорондын нийтийн тээврийн үйл ажиллагааг "Шувуут Баян гол" хоршоо- 46, "Улзын шинэ зам" ХХК- 10 бага оврын тээврийн хэрэгслээр, хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг "Айсвн" ХХК- 12 бага оврын, 4 дунд оврын тээврийн хэрэгслээр тус тус үйлчилгээ үзүүлж байна.

Тус аймаг нь ОХУ-ын Чита мужтай 2 боомтоор буюу Баянуул суман дахь Ульхан-Майхан /225 км/ хилийн боомтоор автомашинаар, Чулуунхороот суман дахь Эрээнцав-Соловьевск /268 км/ хилийн боомтоор вагон, автомашинаар, БНХАУ-лстай 3 боомтоор буюу Чойбалсан суман дахь Хавирга-Ар хашаат /130 км/, Халхгол сумын Баянхошуу-Өвдөг /336 км/, Сүмбэр /360 км/, хилийн боомтоор автомашинаар, Улаанбаатар–Чойбалсан–Хайлаар чиглэлийн олон улсын нислэгээр БНХАУ-д тус тус зорчих боломжтой юм.

Улаанбаатараас Чойбалсан хот хүртэл хатуу хучилттай зам тавигдсанаар автомашинаар дунджаар 8-100 цаг явах боломжтой боллоо.

Харилцаа холбоо: Аймгийн хэмжээнд Мобиком, Скайтел, Юнител болон үүрэн холбооны үндэсний оператор Жи-Мобайл компаниуд үйлчилж байгаагийн зэрэгцээ аймгийн төвд орон нутгийн телевизийн 5 сувгаар, кабелийн 3 телевизийн 80 гаруй сувгаар тус тус нэвтрүүлэг дамжуулж байна.

2017 оноос Юнивишнийг хэрэглэгчид хэрэглэж эхлээд байна.

Аймгийн хэмжээнд 0.7 мянган телефон цэг айл өрх, албан газар ашиглаж байна.

Аймгийн төвөөс Улаанбаатар хоттой холбогдсон өндөр хурдны шилэн кабилаар холбогдсон.

Эрүүл мэнд, боловсрол соёл: Аймгийн хэмжээнд Зүүн бүсийн оношилгоо эмчилгээний төв, Монгол уламжлалт эмнэлэг 1, 3 өрхийн эмнэлэг, 3 сум дундын эмнэлэг, 10 сумын эмнэлэг, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 2, үүдэн эмнэлэг 15, эмийн

сан 14, хортон шавьж ариутгалын газар 1, тус тус ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө үйлчилж байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуулийн 543 бүлэгт 14.9 мянган хүүхэд суралцаж байгаа бөгөөд 17 дотуур байранд 844 хүүхэд амьдарч байна.

Ерөнхий боловсролын 26 сургууль нийт 1366 ажиллагчидтай ба ажиллагсдын 56.7 хувь буюу 775 багш хүүхэд багачуудад эрдэм ном зааж байгаа юм.

Аймгийн 37 цэцэрлэгийн 199 бүлэгт 6.8 мянган хүүхэд хүмүүжиж, 430 үндсэн болон туслах багш ажиллаж байна. Дорнод дээд сургууль, Шинжлэх ухаан техникийн коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд нийт 1685 оюутан суралцаж байна.

Аймгийн хэмжээнд хөгжимт драмын театр 1, номын сан 26, музей болон 13 соёлын төв үйл ажиллагаа явуулдаг.

Гадаад харилцаа: Тус аймаг нь ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот Хянган аймагтай нийгэм, соёл, эдийн засаг, худалдааны шууд харилцаатай. БНСУ-ын Пучонь хот, БНХАУ-ын Жилин хот, Хөх хот, Шилийн гол аймаг зэрэг бусад нөхөрсөг харилцаа тогтоож, хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Амжилт: Дорнод аймаг нь Баатар хот өргөмжлөлтэй ба 2017 онд төрийн дээд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнагдсан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх 22 агентлагийн 60 хувь нь салбарын хэмжээнд улсад 1-2 дугаар байрыг тогтмол эзэлдэг тэргүүний байгууллагууд юм.

Мөн 2017 оны ажил үйлсээрээ шалгарч Монгол Улсын “Тэргүүний аймаг”-аар шалгарсан, Хөлөнбуйр сум 2018 онд Монгол Улсын “Тэргүүний сум”-аар шалгарсан, аймгийн Хөгжимт Драмын театр “Гэгээн муза” урлагийн наадмаас 7 номинацаас цом авч, шилдгийн шилдэг “Гран при” шагналын эзэд болсон амжилт бүтээлээр дүүрэн байна.

Монгол Улсын хамгийн их ногоон байгууламжтай аймаг бөгөөд усан оргилуур бүхий Тусгаар тогнолын талбай, нуур бүхий Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн, хүүхэд залуучуудын Найрамдал парк, наадмын талбай, сурын талбай зэрэг байгууламжуудтай томоохон аймгийн нэг юм.


Энэ онд Чойбалсан хот үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг 9 дүгээр сард тэмдэглэхээр хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, бусад бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна.

## 1.ОРОН СУУЦНЫ НӨХЦЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд шинэ орон сууцны барилгууд нэмэгдэж байгаатай холбогдуулан жил ирэх тутамд орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдэж байна.

Дорнод аймгийн нийт өрхийн 31.5 хувь нь гэрт, 62.0 хувь нь орон сууцанд, 6.5 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.

**Зураг 1: ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, СУМДААР**



Байшинд амьдарч байгаа өрхийг орон сууцны төрлөөр нь авч үзвэл Орон сууцны байшинд 4742, бие даасан тохилог сууцанд 19, сууцны тусдаа байшинд 8682, нийтийн байранд 1124, нийтийн зориулалтын бусад байранд 856 өрх, гэрт 8635 өрх тус тус амьдарч байна.

Байшинд амьдарч байгаа нийт өрхийн 69.3 хувь нь аймгийн төвд 30.7 хувь нь хөдөөд байна.

Гэрт 8.6 мянган өрх амьдарч байгаа бөгөөд үүний 68.7 хувь нь хөдөөд, 31.3 хувь нь аймгийн төвт амьдардаг өрхүүд байна.

Өрхийн тоо 2000 оноос 11.6 хувь буюу 2.4 мянган өрхөөр, 2015 оноос 5.0 хувь буюу 1.1 мянган өрхөөр тус тус нэмэгдсэн байна



**Хүснэгт 1: СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, сумдаар**

Байршил	Бүгд	Үүнээс		Өөрийн
		Бусдын сууцанд түрээсгүй	Бусдын сууцанд түрээстэй	
Баяндун	863	49	16	798
Баянтүмэн	845	124	16	705
Баян-Уул	1 482	294	61	1 127
Булган	607	38	10	559
Гурванзагал	473	64	8	401
Дашбалбар	921	165	9	747
Матад	894	85	65	744
Сэргэлэн	606	36	13	557
Халхгол	889	111	99	679
Хөлөнбуйр	602	36	4	562
Хэрлэн	13 334	1 697	644	10 993
Цагаан-Овоо	1 052	193	6	853
Чойбалсан	843	153	37	653
Чулуунхороот	647	199	11	437
<b>Нийт</b>	<b>24 058</b>	<b>3 244</b>	<b>999</b>	<b>19 815</b>

Нийт өрхийн 13.5 хувь нь бусдын хувийн өмчийн сууцанд түрээсгүй амьдарч байгаа бол, 4.1 хувь нь бусдыг хувийн өмчийн сууцанд түрээстэй амьдарч байна.

Нийт өрхийн 81.4 хувь нь өөрийн хувийн сууцанд амьдарч байгаа нь аймгийн хувьд орон сууцны 102 байшинтай нь гол хүчин зүйл болж байна.

Өрхийн сууцны өмчийн хэлбэрийг хот, хөдөөгөөр ангилж үзэхэд хувийн өмчийн сууцанд түрээсгүй амьдарч байгаа өрх хөдөөд 47.7 хувь, хотод 52.3 хувьтай байна.

Харин хувийн өмчийн сууцанд түрээстэй амьдарч байгаа өрх хөдөөд 64.5 хувь, хотод 35.5 хувьтай байна.

Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх зэрэг асуултад тодорхой хэмжээгээр хариулт өгөх үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Сууцны эзэмшлийг хэлбэрээр нь үзэхэд хэд хэдэн асуудал тодорхой болно.

Дорнод аймгийн нийт өрхийн 82.3 хувь буюу 19815 нь өөрийн эзэмшлийн сууцтай байна. Харин нийт өрхийн 17.7 хувь буюу 4243 өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Эдгээрийн 2341 нь хотын өрхүүд юм.

**2. АХУЙН НӨХЦӨЛ**

Ахуйн нөхцлийн мэдээллийн эх үүсвэр нь Хүн ам, өрхийн мэдээллийн сан юм.

Сүүлчийн жилүүдэд хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр өргөн ашиглах болсон. Сэргээгдэх эрчим хүчний эх

үүсвэрийн хангамж, хүрэлцээг тодорхойлж, цаашид холбогдох бодлого, хөтөлбөр боловсруулах суурь мэдээлэл бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

Нийт өрхийн 75.0 хувь нь төвлөрсөн эрчим хүчинд холбогдсоод байгаа бол дизел станцаар нийт өрхийн 0.6 хувь, сэргээгдэх эрчим хүчээр 21.3 хувь, бага оврын цахилгаан үүсгүүрээр 2.1 хувь нь хангагдсан байна.

Бүх өрхийн 1.0 хувь нь цахилгааны ямар нэг эх үүсвэргүй байна.

## Хүснэгт 2: ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, сумдаар

Байршил	Бүгд	Үүнээс				
		Бага оврын цахилгаан үүсгүүр	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Төвлөрсөн систем	Цахилгааны эх үүсвэргүй
Баяндун	863	53	1	469	326	14
Баянтүмэн	845	42		473	300	30
Баян-Уул	1482	10	1	430	1009	32
Булган	607	6	3	370	228	
Гурванзагал	473	3		291	169	10
Дашбалбар	921	13	1	500	372	35
Матад	894	139	66	356	306	27
Сэргэлэн	606	55	4	352	190	5
Халхгол	889	59	1	272	534	23
Хөлөнбуйр	602	4		386	207	5
Хэрлэн	13334	41	1	153	13137	2
Цагаан-Овоо	1052	25	1	478	525	23
Чойбалсан	843	43	1	394	388	17
Чулуунхороот	647	24	42	208	353	20
<b>Нийт</b>	<b>24058</b>	<b>517</b>	<b>122</b>	<b>5132</b>	<b>18044</b>	<b>243</b>

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Аймгийн хэмжээнд зөөврийн усан хангамжтай өрхийн тоо 18484 буюу 76.8 хувийг эзэлж байна. Энэ нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө амьдардагтай холбоотой.

Харин 5516 буюу 22.9 хувь нь төвлөрсөн халуун, хүйтэн усан хангамжтай байна.

**Хүснэгт 3: ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖААР, сумдаар**

Байршил	Бүгд	Үүнээс				
		Бие даасан систем - халуун, хүйтэн устай	Бие даасан систем - хүйтэн устай	Зөөврийн	Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай
Баяндун	863			858	5	
Баянтүмэн	845			845		
Баян-Уул	1 482		1	1 477	3	1
Булган	607			601	5	1
Гурванзагал	473			473		
Дашбалбар	921			921		
Матад	894	1		888	5	
Сэргэлэн	606			606		
Халхгол	889	2		887		
Хөлөнбуйр	602			595	6	1
Хэрлэн	13 334	4	3	7 850	5 442	35
Цагаан-Овоо	1 052	1	1	1 049		1
Чойбалсан	843			828	14	1
Чулуунхороот	647	2		606	36	3
<b>Нийт</b>	<b>24058</b>	<b>10</b>	<b>5</b>	<b>18 484</b>	<b>5 516</b>	<b>43</b>

**Хүснэгт 4: ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР, сумдаар**

Байршил	Бүгд	Үүнээс			
		Ердийн галлагаа	Нам даралтын зуух	Төвлөрсөн систем	Цахилгаан халаагуур
Баяндун	863	848	9	6	
Баянтүмэн	845	845			
Баян-Уул	1482	1476	1	4	1
Булган	607	601	1	5	
Гурванзагал	473	468	4	1	
Дашбалбар	921	906	15		
Матад	894	877	4	10	3
Сэргэлэн	606	601	4	1	
Халхгол	889	868	19		2
Хөлөнбуйр	602	592	3	7	
Хэрлэн	13334	7607	138	5534	2
Цагаан-Овоо	1052	1042	3	7	
Чойбалсан	843	820	9	14	
Чулуунхороот	647	565	48	33	1
<b>Нийт</b>	<b>24058</b>	<b>18169</b>	<b>258</b>	<b>5622</b>	<b>9</b>

Дээрх хүснэгтэд байшинд суудаг өрхийн дэд бүтцийн хангамж болох халаалтын төрлийн үр дүнг харуулсан.

Нийт өрхийн 75.5 хувь нь ердийн галлагаатай бол 23.4 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байна.

Хөдөө сумдаас хүн ам ихтэй Баян-Уул сумын нийт өрхийн 99.6 хувийг ердийн галлагаатай өрх эзэлж байгаа нь аймгийн нийт ердийн галлагаатай өрхийн 8.1 хувийг эзэлж байгаа нь бусад хөдөөгийн сумдаас өндөр харагдаж байгаа үзүүлэлт юм.

### Хүснэгт 5: ӨРХИЙН ТОО, БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТ, сумдаар

Байршил	Бүгд	Үүнээс			
		Бие даасан систем	Задгай	Төвлөрсөн систем	Цооног
Баяндун	863	2	489	5	367
Баянтүмэн	845		844		1
Баян-Уул	1482		600	4	878
Булган	607	1	381	5	220
Гурванзагал	473		372		101
Дашбалбар	921	1	294		626
Матад	894	3	602	3	286
Сэргэлэн	606	1	526		79
Халхгол	889	1	203		685
Хөлөнбуйр сум	602	2	394	6	200
Хэрлэн сум	13334	16	3470	5442	4406
Цагаан-Овоо сум	1052	1	766	2	283
Чойбалсан сум	843		476	15	352
Чулуунхороот сум	647	12	504	33	98
<b>Нийт</b>	<b>24058</b>	<b>40</b>	<b>9921</b>	<b>5515</b>	<b>8582</b>

Тус аймгийн нийт өрхийн 41.2 хувь нь бохир усаа задгай асгадаг, 35.7 хувь нь цоногт, 22.9 хувь нь төвлөрсөн системд холбогдсон зайлуулдаг бол бие даасан системд холбогдсон өрх 0.2 хувийг эзэлж байна.

Аймгийн төвийн Хэрлэн сумын хувьд хамгийн их хүн амтай, орон сууцны барилга ихтэй учир төвлөрсөн системд холбогдон бохир усаа зайлуулдаг нийт өрхийн 98.7 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 6: ӨРХИЙН ТОО, ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ, сумдаар**

Байршил	Бүгд	Үүнээс		
		Зөвшөөрөгдсөн цэгт	Тогтсон цэг байхгүй	Үйлчилгээний байгууллагаар
Баяндун	863	407	445	11
Баянтүмэн	845	15	542	288
Баян-Уул	1482	967	475	40
Булган	607	193	364	50
Гурванзагал	473	110	301	62
Дашбалбар	921	487	408	26
Матад	894	342	500	52
Сэргэлэн	606	241	352	13
Халхгол	889	468	217	204
Хөлөнбуйр	602	140	287	175
Хэрлэн	13334	36	523	12775
Цагаан-Овоо	1052	580	452	20
Чойбалсан	843	392	427	24
Чулуунхороот	647	296	306	45
<b>Нийт</b>	<b>24058</b>	<b>4674</b>	<b>5599</b>	<b>13785</b>

Өрхийн хатуу хог хаягдлыг нэгдсэн бодлогоор ангилан ялгаж, тогтсон газар зайлуулах, бохир усыг нэгдсэн шугам сүлжээгээр зайлуулж, цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, хөрсний бохирдолд ихээхэн нөлөөтэй. Ялангуяа, хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот суурин газруудад хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, иргэдэд хогоо ялгаж зайлуулах ухамсрыг төлөвшүүлэх зэрэг олон асуудалд энэхүү үзүүлэлтүүд тодорхой хариулт өгнө.

Аймгийн нийт өрхийн 57.3 хувь нь үйлчилгээний байгууллагаар, 23.3 хувь нь хог хаях тогтсон цэг байхгүй, үлдсэн 19.4 хувь нь зөвшөөрөгдсөн цэгт асгаж байна. Үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа өрхийн хувь өндөр байгаа нь орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо, мөн сум бүрт хог тээврийн машин ажиллад болсон нь нөлөөлж байна.

**3.НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар бүтэн өнчин 87 хүүхэд байгаагийн 42 нь эмэгтэй, хагас өнчин хүүхэд 860 байгаагийн 438 эмэгтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтэн өнчин хүүхэд 16 хүүхдээр буурч, хагас өнчин хүүхэд 66 хүүхдээр өссөн.

Өрх толгойлсон эхийн тоо 2822 болсон нь нийт өрх толгойлсон эцэг, эхийн 71.1 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 155 эхийн тоогоор буурсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх онд 4187 байсан бол 2017 оны жилийн байдлаар 4394 болж өссөн үзүүлэлттэй гарлаа.

**Хүснэгт 7: НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Сумдын нэрс	Бүтэн өнчин хүүхдийн тоо	Хагас өнчин хүүхдийн тоо	Өрх толгойлсон хүний тоо	Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо	18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон өрхийн тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо
Хэрлэн	48	425	1 096	997	718	2511
Баяндун	11	47	185	176	178	200
Баянтүмэн	3	15	261	125	84	143
Баян-Уул	4	86	358	296	122	209
Булган	3	26	120	118	34	113
Гурванзагал	-	6	201	92	62	75
Дашбалбар	1	35	279	201	145	179
Матад	1	27	105	71	66	129
Сэргэлэн	-	15	244	104	50	99
Халхгол	4	44	341	178	90	87
Хөлөнбуйр	-	16	129	79	79	147
Цагаан-Овоо	5	73	430	198	124	244
Чойбалсан	7	33	155	125	58	162
Чулуунхороот	-	12	65	62	49	96
<b>ДҮН</b>	<b>87</b>	<b>860</b>	<b>3 969</b>	<b>2 822</b>	<b>1 859</b>	<b>4 394</b>

**4.ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Аймгийн хэмжээнд Зүүн бүсийн оношилгоо эмчилгээний төв, Монгол уламжлалт эмнэлэг 1, 3 өрхийн эмнэлэг, 3 сум дундын эмнэлэг, 10 сумын эмнэлэг, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 2, үүдэн эмнэлэг 15, эмийн сан 14, хортон шавьж ариутгалын газар 1, тус тус ард иргэдийнхээ эрүүл мэндийн төлөө үйлчилж байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар 1922 эх амаржиж, нийт нас баралт 430 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын шалтгааныг төрлөөр нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 134 тохиолдол бүртгэгдсэн ба нийт нас баралтын 31.2%, осол гэмтлийн нас баралт 59 тохиолдол буюу 13.7%-ийг тус тус эзэлж байна.

Хүн амын дотор өвчлөл 39.7 мянган тохиолдол бүртгэгдэж, эмнэлэгт 19.0 мянган хүн хэвтүүлэн эмчилж, 143.8 мянган ор хоног ашиглажээ. Амбулаториор 392.4 мянган хүнд үзлэг хийж, эмнэлэгт 19.0 мянган хүнийг хэвтүүлэн эмчиллээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны 12 сард 2915 болж, өмнөх оны мөн үеийнхээс 337 хүн буюу 13.0 хувиар өсөхөд салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 652

## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(22.4%), заг хүйтэн өвчнөөр 828 (28.4%) тохиолдол, трихоминиаз 498 (17.0%) тохиолдол тус тус бүртгэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хувийн хэвшлийн 22 эмнэлэг, 16 эмийн сангууд 340.7 мянган хүнд үйлчилж, 2511.2 сая төгрөгийн орлоготой ажиллалаа.

### Хүснэгт 8: ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сумдаар

д/д	Сумын нэр	Төрсөн эх			Амьд төрөлт					Нийт нас баралт					Цэвэр өсөлт	
		2016	2017		2016		2017			2016		2017			2016	2017
			Бүгд	Хот	б/г	1000	б/г	1000	Хот	б/г	1000	б/г	1000	Хот		
1	Баяндун	57	54	53	57	19.09	54	17.90	53	18	6.03	14	4.64	1	13.06	13.3
2	Баянтүмэн	43	45	45	43	20.11	46	20.60	46	12	5.61	9	4.03		14.50	16.6
3	Булган	49	37	37	49	29.00	37	21.39	37	12	7.10	5	2.89		21.90	18.5
4	Гурванзагал	35	34	31	35	25.87	35	25.49	32	7	5.17	4	2.91		20.69	22.6
5	Матад	64	47	43	65	24.94	46	17.67	42	10	3.84	9	3.46	2	21.11	14.2
6	Сэргэлэн	45	46	45	45	23.30	48	24.74	47	3	1.55	7	3.61	1	21.74	21.1
7	Хөлөнбуйр	45	31	31	45	25.94	32	18.30	32	13	7.49	9	5.15	1	18.45	13.2
8	Цагаановоо	76	65	64	75	21.56	66	18.96	64	14	4.02	22	6.32	1	17.53	12.6
9	Чулуунхороот	39	39	28	39	22.83	39	22.69	29	9	5.27	5	2.91	1	17.56	19.8
10	Чойбалсан	55	53	49	56	21.92	54	20.99	50	13	5.09	9	3.50	1	16.83	17.5
	Сумын эмнэлэг	508	451	426	509	22.95	457	20.39	432	111	5.00	93	4.15	8	17.94	16.2
11	Баянуул	97	93	77	95	21.06	93	20.37	77	40	8.87	21	4.60	2	12.19	15.8
12	Дашбалбар	80	68	53	81	24.97	67	20.68	53	26	8.01	16	4.94	1	16.95	15.7
13	Халхгол	78	68	65	78	25.62	68	22.59	66	23	7.56	17	5.65	3	18.07	16.9
	<b>Сум дундын</b>	<b>255</b>	<b>229</b>	<b>195</b>	<b>254</b>	<b>23.52</b>	<b>228</b>	<b>21.08</b>	<b>196</b>	<b>89</b>	<b>8.24</b>	<b>54</b>	<b>4.99</b>	<b>6</b>	<b>15.28</b>	<b>16.1</b>
14	БОЭТөв	1304	1242	1242	1313	30.74	1249	28.46	1249	317	7.42	74	1.69	74	23.32	26.8
15	Асралт үйлс	444	378	378	448	32.12	379	26.76	379	65	4.66	59	4.17	59	27.46	22.6
16	Мянган жаргалан	308	352	352	307	22.64	352	25.06	352	80	5.90	74	5.27	74	16.74	19.8
17	Ягаан цээнэ	455	431	431	460	30.36	436	28.50	436	99	6.53	76	4.97	76	23.83	23.5
	<b>Нийт дүн</b>	<b>2067</b>	<b>1922</b>	<b>1863</b>	<b>2076</b>	<b>27.42</b>	<b>1934</b>	<b>25.08</b>	<b>1877</b>	<b>517</b>	<b>6.83</b>	<b>430</b>	<b>5.58</b>	<b>297</b>	<b>20.59</b>	<b>19.50</b>

## 5.СУРЧ, БОЛОВСРОХ НӨХЦӨЛ

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуулийн 543 бүлэгт 14.9 мянган хүүхэд суралцаж байгаа бөгөөд 17 дотуур байранд 844 хүүхэд амьдарч байна.

Ерөнхий боловсролын 26 сургууль нийт 1366 ажиллагчидтай ба ажиллагсдын 56.7 хувь буюу 775 багш хүүхэд багачуудад эрдэм ном зааж байгаа юм.

Аймгийн 37 цэцэрлэгийн 199 бүлэгт 6.8 мянган хүүхэд хүмүүжиж, 430 үндсэн болон туслах багш ажиллаж байна. Дорнод дээд сургууль, Шинжлэх ухаан техникийн коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд нийт 1685 оюутан суралцаж байна.

Аймгийн хэмжээнд хөгжимт драмын театр 1, номын сан 26, музей болон 13 соёлын төв үйл ажиллагаа явуулдаг.

Аймгийн БТСГ-ын дэргэд бокс, жудо, хөнгөн атлетик, бадминтон, сагс, гар бөмбөг, хөл бөмбөг, теннисны секцүүд хичээллэдэг. Хөлбөмбөгийн стандартын талбайд нас насны ангиллаар 75 хүүхэд тогтмол хичээллэдэг ба зуны сургалтаар 350 хүртэлх хүүхэд хамрагддаг.

Мөн аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд ардын болон цэнгээнт бүжиг, хөтлөгч, дууны, хөгжмийн, зургийн англи хэлний дугуйланд 140 гаран хүүхэд хамрагджээ.

Циркийн тоглолт, үзүүлбэр үзүүлдэг циркийн 1 бүлэг үйл ажиллагаа явуулж байна.

## **6.ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ**

2017 оны жилийн эцсийн байдлаар 12 сард 582 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 31 хүн нас барж, 254 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 100 хэргээр буюу 20.7 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 3262.9 сая төгрөгийн хохирол учирсны 15.7 хувь буюу 512.2 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Нийт гарсан гэмт хэргийн 133 хэргийг 158 хүн согтуугаар үйлдсэн байна.



**Хүснэгт 9: ГЭМТ ХЭРГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	Гэмт хэрэг	Илрээгүй	Хүн алах	Хүчин дэх	Дээрэм дэх	Танхай рах	ББМГУ	Булаах	Хулгайлах	Үүнээс		ХАБЭ	Залилах	Завших	АТГХ	Бусад
										ИӨХ	Мал Х					
	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017	2017
Хэрлэн сум 1 баг	44	15	1	2	3		12		15	15		6				5
2 баг	30	7	1			1	10		10	10	1	1	1	1		5
3 баг	16	5	1				5		9	8						1
4 баг	47	14		1	2		17		23	23	1	2		1		1
5 баг	5	1					4		1	1						
6 баг	104	25		2	4	3	59	1	15	15		4	7	2		7
7 баг	41	19		1	2	2	17	1	7	7		3	4	1		3
8 баг	11	2		2			3		4	3		2				
9 баг	25	9			3	1	10		7	7		1	2	1		
10 баг	50	17			1	2	26		14	14		4				3
ХЭРЛЭН СУМ	373	11	3	8	15	9	16	2	10	10	2	2	1	6		2
Баян-Уул	18	5					5		7	4	3	2		2		2
Баяндун	16	5			1		5		8	2		1				1
Дашбалбар	12	3					7		1		1	1		1		2
Чулуунхороот	5	2					3		2	1	1					
Гурванзагал	7	6	1				1		5	2	2					
Чойбалсан	23	11	1				3		10	1	9		1	1		7
Сэргэлэн	12	6					2		9	2	6	1				
Цагаан-Овоо	16	5	1				5		3	1	5	3				4
Баянтүмэн	16	8					3		9	3	9	1		1		2
Булган	29	14					3		18	4	8	2		3		3
Хөлөнбуйр	9	3				1	1		3	2	5	3				1
Матад	18	4		1			2		6	4		2				7
Халх гол	23	9				2	2		7	6						1
<b>ДОРНОД АЙМАГ</b>	<b>577</b>	<b>19</b>	<b>6</b>	<b>9</b>	<b>16</b>	<b>12</b>	<b>20</b>	<b>2</b>	<b>19</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>6</b>
		<b>5</b>					<b>5</b>		<b>3</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>4</b>		<b>6</b>

Үйлдэгдсэн бүх хэргийн 193 буюу 33.1 хувь нь хулгайн хэрэг, үүнээс малын хулгайн хэрэг 58 буюу 30.0 хувийг эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд 50.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 26.9 пунктээр өссөн байна.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ:**

- [www.1212.mn](http://www.1212.mn)
- Хүн ам, өрхийн мэдээллийн сан
- Дорнод аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны жилийн танилцуулга